

**ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БАРИЛГА, АВТОМАШИН, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ, ЗАСВАР
ҮЙЛЧИЛГЭЭ, ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Г.АЗЖАРГАЛЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт			Үнэлгээ
		Шалгуур үзүүлэлт	1-р улирлын хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	
1	2	3	4	5	6
НЭГ. НЭГ. “Архангай аймгийн эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөлтийг боловсруулан, салбарын тэргүүлэх чиглэл аймгийн хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд суурилан хэрэгжүүлэх” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					
1.1	Арга хэмжээ №1.1. Эрүүл мэндийн салбарт 2023 онд нэн шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтийн тооцоог нэгж бүрээр гарган, бодит хэрэгцээнд тулгуурласан үндэслэл бүхий төлөвлөлтийг боловсруулан батлуулах.	Батлагдсан төлөвлөгөөний тоо- 1	100 хувь	Архангай аймгийн Эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг нэгж тус бүрээр боловсруулан байгууллагын даргаар батлуулсан. Эрүүл мэндийн салбарын Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд тусгуулах санал боловсруулан ХБХОХэлтэст хүргүүлсэн.	100
1.2	Арга хэмжээ №1.2. Нэн шаардлагатай хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн саналыг ЭМЯ, Аймгийн Засаг Даргын Тамгын Газар болон бусад хандивлагч, санхүүжүүлэгч тал, донор байгууллагуудад албан бичгээр хүргүүлэн санхүүжилтийг шийдвэрлүүлэх. https://publicinvestment.gov.mn/	Шийдвэрлэгдсэн санхүүжилт 246 сая төгрөг	100 хувь	2025 онд шаардлагатай хөрөнгө оруулалтыг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS- www.publicinvestment.gov.mn) цахим программд шивж оруулсан. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд нэн шаардлагатай хөрөнгө оруулалтын санал	100

	Цахимд шивж оруулах			боловсруулан ЭМЯ, Аймгийн засаг даргын тамгын газар болон УИХ- гишүүдэд албан бичгээр хүрүүлсэн. 2024 онд эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтад орон нутгийн төсвөөр 390,3 сая, ЭМЯ-ны санхүүжилтээр 952,7 сая, түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлд 1,280 сая, эрүүл мэндийн байгууллагуудын компьютерын хангалт 715 сая, багийн эмч нарын унаа 250 сая нийтдээ 3,6 тэрбум төгрөгийн санхүүжилт шийдвэрлэгдсэн.	
ХОЁР. “Эрүүл мэндийн салбарын хэмжээнд дэд бүтэц, барилга, автомашин, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг стандарт түвшинд хүргэх” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					
2.1	Арга хэмжээ 2.1. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд нэн шаардлагатай байгаа шинэ барилга, их засвар үйлчилгээ хийх, эрүүл мэндийн барилга байгууламжийн төлөвлөлтийг хийж дараа оны төсөвт тусган хэрэгжүүлэх	Батлагдсан хөрөнгө оруулалтын дүн	тийм	Зоонозын өвчин судлалын төв, болон Цэнхэр, Жаргалант, Булган, Өлзийт, Цэцэрлэг сумдын эрүүл мэндийн төвүүдийг нэг маягийн зургаар холболт хийж шинээр барих, Өндөр-Улаан, Хангай, Хотонт сумдын эрүүл мэндийн төвүүдэд өргөтгөл хийх санал боловсруулан төлөвлөлтийн программд оруулсан.Цэнхэр сумын эрүүл мэндийн төвийн шинэ барилгын зураг төсөв хийгдэж батлагдсан.	100

2.2	Арга хэмжээ 2.2.Тариат сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг дуусгуулан байнгын ашиглалтад оруулах.	Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь Хийсэн хяналтын тоо	тийм	Тариат сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга угсралтын ажил 100 хувьд хүрсэн. Инженерийн шугам сүлжээний нэмэлт санхүүжилтийн хүсэлтийг орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлэхээр аймгийн ЗДТ-гын газарт албан бичгээр уламжилсан.Ирэх оны төсөвт суулгахаар шийдвэрлэгдсэн.	100
2.3	Арга хэмжээ 2.3. Хөдөөгийн багийн бага эмч нарыг 100 хувь унаагаар хангаж шуурай байдлыг хангах.	Хангагдсан мотоциклын тоо	Тийм	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хөдөөгийн 76 багт багийн эмчийг унаагаар хангах 250 сая төгрөг шийдвэрлэгдэн энэ оны 3-р улиралд хөдөөгийн 77 багийн бага эмчийг унаагаар бүрэн хангагдсан.	100
	Арга хэмжээ 2.4. Эрүүл мэндийн салбарын барилга байгууламж дэд бүтцийг сайжруулах, урсгал засвар үйлчилгээг тогтмол хийж байгууллагын хэвийн үйл ажиллагааг 100 хувь хангах. /2-3 байгууллагын их засвар, өргөтгөлийн зураг төсөв хийж батлуулах,2 байгууллага халаалт дулаан, 1-2 байгууллага цэвэр	Их засвар болон урсгал засвар хийгдсэн барилгын тоо Халаалт дулаан шийдвэрлэсэн байгууллагын тоо	100 хувь	Хотонт, Батцэнгэл сумдын эрүүл мэндийн төвүүдийн ариун цэврийн байгууламжид засвар үйлчилгээ хийх зураг төсөв боловсруулах ажлын даалгаврыг ГХБХБГазартай хамтран боловсруулсан. Япон улсын “Хөгжингүй, тогтвортой Ази, Номхон далайн бүсийн төлөө Япон сан”-ийн буцалгүй тусламжийн	100

	бохир усны байгууламж/	Цэвэр бохир ус шийдэгдсэн байгууллагын тоо		санхүүжилтээр, Чулуут сумын эрүүл мэндийн төвд засвар үйлчилгээ хийгдэхээр шийдвэрлэгдсэн.Эрүүл мэндийн газрын барилгад их засвар зураг төсөв хийлгэн ЗДТГ-т хүргүүлэн 2025 оны Орон нутгийн хөрөнгө оруулалтад тусгуулсан.	
	Арга хэмжээ 2.5 Салбарын хэмжээнд гадна тохижилт үйлчилгээг хийх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчин нөхцөлийг сайжруулсан талаарх тайланг авч үнэлгээ хийх	Тарьсан модны тоо зүлэгжүүлсэн талбай м2	100 хувь	Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг тохиолдуулан эрүүл мэндийн салбарын нийт 24 байгууллага өөрийн эзэмшил болон бусад талбайд нийтдээ 2354 ширхэг мод суулгац нэмж суулгасан, шинээр 8 цэцгийн мандал 240м ² талбайг зүлэгжүүлсэн байна.Байгууллагын хашаанд 4 мод нэмж тарьсан.	100
	Арга хэмжээ 2.7 Эрүүл мэндийн байгууллагуудад нэн шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх.	Тоног төхөөрөмжөөр хангагдсан сумдын эрүүл мэндийн төвийн тоо	100 хувь	Эрүүл мэндийн байгууллагуудад нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт хийх хүсэлт төлөвлөлтийг боловсруулан ЭМСайдад албан бичгээр хүргүүлсэн. 2024 онд эрүүл мэндийн салбарын эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтад 1 тэр бум 324 сая төгрөг шийдвэрлэгдсэн. Салбарын	100

				хэмжээнд эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт өмнөх оны мөн үеэс 4 хувиар нэмэгдэж 94 хувьд хүрсэн.	
	Арга хэмжээ 2.6 Зургаан сумын эрүүл мэндий төвийг шүдний иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангах.	Тоног төхөөрөмжөөр хангагдсан сумдын эрүүл мэндийн төвийн тоо	100 хувь	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Булган, Цахир, Цэцэрлэг, Өлзийт, Өгийнуур, Хотонт 6 сумын эрүүл мэндийн төвд 298,2 сая төгрөгийн өртөг бүхий шүдний кабинетын иж бүрэн тоног төхөөрөмжийн хангалт бүрэн хийгдэж дууссан. Дээрх сумдад тоног төхөөрөмжийн хангалт хийгдсэнээр сумдын эрүүл мэндийн төвүүдийн 84 хувь нь шүдний иж бүрэн тоног төхөөрөмжтэй болно.	100
	Арга хэмжээ 2.8. 2023 оны авто машин ашиглалтын тайланд дүн шинжилгээ хийж түргэн тусламжийн авто машины парк шинэчлэлтийг 2-4 суманд хийх	Парк шинэчлэлтийн хувь	100 хувь	2024 онд эрүүл мэндийн салбарын хэмжээнд нийт 1,2 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтаар туулах чадвар сайтай Ланд-78 авто машин, 11 сумдын эрүүл мэндийн төвүүдэд парк шинэчлэлт хийгдсэнээр, автомашины хангалт 100 хувьд хүрж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шуурхай байдал бүрэн хангагдаад байна.	100

	Арга хэмжээ 2.9. ЭМХТ-тэй хамтран эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж буй эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулгын ажлыг бүх нэгжид зохион байгуулах.		90 хувь	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газар Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 249 дүгээр тушаалаар батлагдсан “Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 19 сум 3 өрх болон аймгийн нэгдсэн эмнэлгийн шалгалт тохируулгад хамрагдах тоног төхөөрөмжийн мэдээллийг боловсруулан хүргүүлсэн.	70
	Арга хэмжээ 2.10. Сумдын эрүүл мэндийн төвүүдийн яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн ашиглалтын сургалтыг бүсчлэн зохион байгуулах,		100 хувь	Аймгийн засаг даргын 2024 оны 11 сарын 11-ны өдрийн А/790 дугаар захирамжаар батлагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг сумдын төрийн байгууллагуудад зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд гишүүнээр оролцон 2024 оны 11 сарын 18-наас 29-ны өдөр хүртэл нийт 6 суманд эмнэлгийн яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал болон ашиглалтын талаар зөвлөн туслах, сургалт, мэдээллийг газар дээр өгч ажилласан. Мөн	100

				дэмжлэгт хяналтыг 3 суманд хийж тоног төхөөрөмжийн мэдээллийн сан үүсгэх сургалт мэдээлэл өгсөн.	
	Арга хэмжээ 2.11. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт ангиограм нэвтрүүлэх төсөл боловсруулан, хандивлагчдад хандах	Төсөл хандивлагчид хандсан эсэх	100 хувь	ЭМСайдад ангиографийн хангалт хийлгэх хүсэлтийг хүргүүлсэн. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх чиглэл (2025 он)-ийн саналд тусган ЭМЯ-нд хүргүүлсэн.	100
“ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					
	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн богино хугацааны сургалтад хамрагдан мэдлэг чадвараа дээшлүүлэх	2 багц цагийн сургалт	100 хувь	2023 оны 05 сарын 22-ны өдөр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах тухай Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2019 оны А/370 тоот тушаалын дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн богино хугацааны сургалтад хамрагдсан.	100

